БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2026 оны 10 сарын 14 өдөр Дугаар А/224 Улаанбаатар хот

Ажлын хэсэг, Шуурхай баг
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.4, 32.1.8, 32.1.9 дэх заалт, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 387 дугаар тогтоол, Улсын Онцгой комиссын 2026 оны 03 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Баавгайн аюулаас урьдчилан сэргийлэх Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, хариу арга хэмжээ авах Шуурхай багийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Суурьшлын бүсэд нэвтэрсэн баавгайг аюулгүй болгох, мэргэжлийн байгууллагын заавар зөвлөмжийн дагуу зөөж шилжүүлэх, хамгаалах бүсчлэлийг тогтоох болон биотехникийн арга хэмжээг хэрэгжүүлэх, иргэдийн амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд бодит аюул учруулж болзошгүй болон учруулж байгаа тохиолдолд устгах арга хэмжээг мэргэжлийн байгууллагын оролцоотойгоор зохион байгуулах, үүрэг гүйцэтгэж буй шуурхай багийн бүрэлдэхүүний аюулгүй байдалд онцгой анхаарч, Шуурхай багийн үйл ажиллагааг нэгдсэн удирдлага зохицуулалтаар хангаж, хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар тухай бүр танилцуулахыг Ажлын хэсэг (Г.Дагвадорж)-т үүрэг болгосугай.

3.Баавгай үзэгдсэн, байршсан болон аюул учруулж болзошгүй нөхцөл байдлын талаарх мэдээ, мэдээлэл, урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг, зөвлөмжийг иргэд, олон нийтэд мэдээлж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (Б.Отгонжаргал), хүнсний хаягдал, ил задгай хог, малын гаралтай үлдэгдэл болон бусад эрсдэлт хүчин зүйлийг бууруулах арга хэмжээ авч ажиллахыг Багахангай тохижилт ОНӨААТҮГ (Б.Гэрэлмаа), иргэдийн аюулгүй байдлыг хангах, урьдчилан сэргийлэх, тусламж үзүүлэх, хариу арга хэмжээ авахад шаардлагатай хүн хүч, техник хэрэгсэл, холбоо мэдээллийн бэлэн байдлыг хангах ажлыг хамтран хэрэгжүүлж ажиллахыг Цагдаагийн хэлтэс (Т.Лхагвасүрэн), Онцгой байдлын хэлтэс (Б.Цогбадрах), Эрүүл мэндийн төв (Х.Ганбат), Багахангай тохижилт ОНӨААТҮГ(Б.Гэрэлмаа), Телекамерын хяналтын дэд төв ОНӨААТҮГ (Б.Хишиг-Ундрал), Багахангай гэрэлтүүлэг, ногоон байгууламж ОНӨААТҮГ (Ч.Батхуяг)-т тус тус үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Х.Цогцэцэг)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА А.СҮХБОЛД

1226100640

AJIL\2026 он ажил\захирамж

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2026 оны 02 дугээр сарын 11-ны өдрийн
А/224 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга:	Дүүргийн менежер
Гишүүд:	Засаг даргын Тамгын газрын дарга Онцгой байдлын хэлтсийн дарга Цагдаагийн хэлтсийн дарга Хотын стандарт, тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн дарга Эрүүл мэндийн төвийн дарга 1 дүгээр хорооны Засаг дарга 2 дугаар хорооны Засаг дарга Мал эмнэлгийн тасгийн Улсын байцаагч Теле камерын хяналтын дэд төвийн дарга
Нарийн бичгийн дарга:	Гамшгаас хамгаалах төлөвлөлт, бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2026 оны 10 дүгээр сарын 14-ны өдрийн
А/224 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

ШУУРХАЙ БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга:	Дүүргийн менежер
Гишүүн, төлөөлөл:	Гал түймэр унтраах, аврах 80 дугаар ангийн бэлтгэл ээлж Цагдаагийн хэлтсийн бүлэг Эрүүл мэндийн төвийн эмнэлгийн тусламжийн баг Хотын стандарт, тохижилт, нийтийн аж ахуйн хэлтийн дарга Мал эмнэлгийн тасгийн Улсын байцаагч Хэвлэл мэдээлэл хариуцсан ажилтан Багахангай тохижилт ОНӨААТҮГ Багахангай гэрэлтүүлэг, ногоон байгууламж ОНӨААТҮГ Теле камерын хяналтын дэд төв